


БАЯНДУН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

# 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛТЫН ТАЙЛАН

2024.06.19

ЗАХИРАЛ Ш.БАТЖАВ

# Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн ерөнхий мэдээлэл

Нийт багшийн тоо




Мэргэжлийн зэрэгтэй багшийн тоо







## <u>Дутагдалтай багш, ажилтан</u>

| | | |
|---|---|---|
| **Математик-1** | **Биологи, эрүүл мэнд-1** | **Бага ангийн багш-2** |
| **Технологийн багш-2** | **Хөгжмийн багш-1** | **Хоолзүйч-1** |

## 1.Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах

Сургуулийн хэмжээнд зайн, цахим сургалтыг зохион байгуулахад шаардлагатай ухаалаг самбар 5, цахим сургалтыг зохион байгуулахад ашиглах 35 ш таблет, дотуур байрын сурагчдын хэрэгцээнд 7 ш таблет ашиглаж байна.





### СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

| № | Кабинет | Санхүүжилт | Мөнгөн дүн |
|---|---|---|---|
| 1 | VR төхөөрөмжинд суурилсан химийн цахим лаборатори | ОНХС | 20.000.000 |
| 2 | Газарзүйн кабинет | Уул уурхайн хандив | 24.000.000 |
| 3 | Бага ангид ... | Уул уурхайн хандив | 24.000.000 |
| 4 | Гадаад хэлний лингафон | ОНХС | 27.500.000 |







## 2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдолыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

### МАССЫН ОЛИМПИАД

Сурагчдын англи хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, сурах сонирхол, хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэх зорилгоор “АНГЛИ ХЭЛНИЙ МАССЫН ОЛИМПИАД”-ыг 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Цаашид жил бүр 5-12 дугаар ангиудын дунд зохион явуулах төлөвлөгөөтэй байна.



### МАТЕМАТИКИЙН БАЯР

1985 оны төгсөгчдийн санаачлага, хандиваар 2015 оноос эхлэн 9 дэх жилдээ математикийн стандарт бодлогын уралдааныг зохион явуулж байна. 2023 оноос олимпиадыг өргөжүүлэн хойд сумдын дунд бүсийн хэмжээнд зохион явуулж байна. Ингэснээр сургуулийн математикийн амжилтад ахиц гарч амжилт тасралтгүй үргэлжилж байна.



### БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ-2024

Байгалийн ухааны хичээлийн амжилт ахицыг нэмэгдүүлэх, ээлжит хичээлээр олж авсан мэдлэг чадварыг хэрэглээ болгох, сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Байгалийн ухааны судлагдахууны баг сар бүр сурагчдын дунд төлөвлөгөөний дагуу танин мэдэхүйн бичил уралдаан тэмцээнүүдийг зохион явуулсан.



# 2. 2023-2024 оны хичээлийн жилийн амжилт





Улсын “ТҮҮХ”-ийн 26-р олимпиадад 12-р ангийн сурагч Э.Баярдэлгэр 9-р байр

“**ХҮРЭЛ ТУЛГА**” улсын уралдаанд 7б ангийн сурагч Х.Цэцэгжаргал 10-р байр.



Хүн домог Монгол туургатны үндэсний их наадмын ардын тайзны бүжиг төрөлд хамтлагаараа 3-р байранд шалгарч, Япон улсад болох Фестивальд оролцох эрхээр шагнуулсан.

- Улс, аймаг, бүсийн хэмжээнд амжилт гаргасан 52 сурагчийг “**АМЖИЛТЫН БАЯР**” үйл ажиллагааны хүрээнд хүлээн авч хүндэтгэл үзүүлэн “**БАТЛАМЖ**” гардуулан сурагч бүрийн гэр бүлд “**ТАЛАРХЛЫН ЗАХИДАЛ**”-ыг хүргүүлсэн.
- Өөрөө болон сурагчдаа амжилттай бэлтгэсэн багш нарт 20-40 хувийн урамшууллыг 8 багшид олгосон.

**2023-2024 оны хичээлийн жилд аймаг, улсад амжилт гаргасан сурагчдын бэлтгэсэн багш нарын бүртгэл**

15.5.2024

| № | Бэлтгэсэн багш | Сурагчийн овог нэр | Анги бүлэг | Аймаг | | Улс | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оролцсон уралдаан | байр | оролцсон уралдаан | байр |
| 1 | Ц.Батболд | Төмөрбат Төрбат | 10а | Төрөлжсөн олимпиад-математик төрөлд | 3 | Кенгру | 2 |
| | | Батжав Төгөлдөр | 6б | | 2 | Кенгеру | 3 |
| | | Сугарцэрэн Эрдэнэбүрэн | 5а | | 1 | | |
| | | Өлзийбаатар Ууганбаатар | 9б | | | Олон улсын "Пазлл" олимпиад Кенгуру -математик | 3 III зэргийн |
| | | Өөрөө | | Төрөлжсөн олимпиад багш төрөлд | 4 | Улсын олимпиадад оролцсон | |
| 2 | А.Отгонжаргал | Энхбат Батдэлгэр | 12а | төрөлжсөн олимпиад-түүх | 1 | төрөлжсөн олимпиад- III даваа-түүх | 7 |
| | | Энхбат Баярдэлгэр | | төрөлжсөн олимпиад-газар зүй | 5 | | |
| | | Шилдэг дугуйлан | | Байгаль шинжлэл-2024 | 2 | | |
| 3 | Ч.Долгорханд | Отгонжаргал Цолмон | 12а | төрөлжсөн олимпиад-орос хэл | 1 | | |
| 4 | Ч. Эрдэнэчулуун | Дугардорж Насанжаргал | 10а | ААШ-хөнгөн | 3 | УАШ-д оролцож байна | |
| | | Бунчиндорж Хишигжаргал | 10б | | | | |
| | | Бямбадолгор Болормаа | 11а | | 1,3 | | |
| | | Бямбадорж Батбаяр | 11а | | 3 | | |
| 5 | А. Нямдулам Г.Нина | Хүрэлчулуун Цэцэгжаргал | 7б | Хүрэл тулга уралдаан | 1 | Улсын уралдаанд амжилттай оролцсон | |
| | | Буянцог Буянжаргал | 9а | | 2 | | |
| 6 | С. Төрбат | Багийн бүтээл | 7-10 | Байгаль шинжлэл - 2024 "Шилдэг бүтээл" | 1 | | |
| | | Багийн олимпиад | 8б | Туршилтат олимпиад | 5 | | |
| 7 | А. Батгэрэл | Г.Отгонсүрэн | 10а | Байгаль шинжлэл шилдэг бүтээл-Хими | 3 | | |
| | | Өөрөө | | Төрөлжсөн олимпиад биологи хичээлийн багш төрөлд | 5 | | |
| 8 | Г.Балжмаа | Өөрөө | | Төрөлжсөн олимпиад мэдээллийн технологи хичээлийн багш төрөлд | 4 | | |

# 3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

Багшийн болон сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд анализ хийж, өмнөх жилийн үнэлгээний үр дүндээ шинжилгээ хийж, анхаарах шалгуур, заалтаар хийх ажлаа төлөвлөн сургуулийн менежментийн загвараа тодорхойлсон ба багшийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажилласан.

- **Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 2 жил IV индексээр үнэлэгдсэн.**
- **Гүйцэтгэлийн үнэлгээний I-IV түвшинд үнэлэгдсэн багшийн тоо-9.**
- **Өмнөх жилийн үнэлгээнээс түвшин буурсан багшийн тоо-4**
- **Түвшин ахисан багшийн тоо-3**

**Б**агшийн мэргэжлийн хөгжлийг хангах сургуульд суурилсан 5 МХБ ажилласан. Бага ангийн түвшинд сурагчдын унших чадварыг ахиулах, суурь бүрэн дунд боловсролын түвшинд сурагчдын бие даах чадварыг нэмэгдүүлэх болон багш нарын цахим хэрэглээг сайжруулахад чиглэж ажилласан. Үүний үр дүнд байгалийн ухааны багш нарын МХБ нь “Байгаль шинжлэл-2024” уралдаанд сурагчдаа амжилттай бэлтгэж оролцсон.

**АНХААРЧ СОНСЪЁ, АНЗААРЧ ХАРЪЯ**

Сургуулийн менежментийг сайжруулах зорилтот жилийн хүрээнд улирал бүр сурагчдаа сонсох зорилгоор “АНХААРЧ СОНСЪЁ, АНЗААРЧ ХАРЪЯ” уулзалт хэлэлцүүлгийг 9-12 дугаар ангийн төлөөлөл сурагчидтай зохион байгууллаа. Уулзалтаар өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн ажлаа дүгнэн дараагийн улиралд хэрэгжүүлэх ажлаа төлөвлөн ярилцаж, сурагчдаас гарсан саналыг сарын ажлын төлөвлөгөөндөө тусган ажилласан. Үүний үр дүнд ахлах ангийн сурагчид нь Дорнод ахлах сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, танилцах багтаа хамтран ажиллах багшаа өөрсдөө сонгосноор сурагчдын өөрсдийн санаачилсан ажлаа үр дүнтэй хэрэгжүүлэх оролцоо нэмэгдсэн.











## 3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

Сургуулийн менежментийг хэрэгжүүлэх “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье” зорилтын хүрээнд сурагчдын оролцоо, хөгжлийг нэмэгдүүлэх үүднээс “1 багш- 10 сурагч” үйл ажиллагааны хүрээнд 8 багш өөрсдийн чадамжиндаа тулгуурлан дугуйлан хичээллүүлж 100 гаруй сурагчдыг хамруулж ажилласан болно. Үүний үр дүнд нийт сурагчдын 30 орчим хувь нь гар урлал, 30 хувь нь IQ буюу математик сэтгэлгээг хөгжүүлэх, бусад сурагчид нь хэл яриа хөгжүүлэх сургалтад суралцсан болно. Хүн болох багаасаа төсөл хөтөлбөрийн хүрээнд спорт, гадаад хэл, авьяас чиглэлээр 9 төрлийн дугуйланд 216 сурагч хамрагдсан.








## 4. “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

“Тэргүүлэх багшийн манлайлал” үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг. Энэхүү үйл ажиллагааны зорилго нь тэргүүлэх багшийн шилдэг аргазүйг бусад багш нартаа түгээх, ажлын тэргүүн туршлага, хүүхэд хөгжүүлэх дэвшилтэт аргазүйг сурагч, эцэг эхчүүдэд танилцуулах. “Тэргүүлэх багшийн манлайлал” үйл ажиллагаанд нийт 260 гаруй сурагчид, 20 гаруй багш, 50 гаруй эцэг эхчүүд хамрагдсан. Тэргүүлэх багш Д.Цэндэм нь 4-р ангийн “Хүн байгаль” хичээлийг цахим программ ашиглан зохион байгуулсан ба багш Ж.Алтансувд нь бага боловсролын нийт сурагчдад тэдний танин мэдэхүйг дэмжсэн үйл ажиллагааг цувралаар зохион байгууллаа. Мөн багш Д.Батчимэг нь “Оюун ухаанаа хөгжүүлэхүй” сэдвээр өөрийн ангийн эцэг эхчүүдтэй хамтран сурагчдыг оюун ухаан хөгжүүлэх олон төрлийн тоглоомоор хөгжүүлэх шилдэг арга, туршлагаа бусад ангийн эцэг эхчүүдэд танилцуулж, хүүхдийн цахим хэрэглээг багасгах, гэр бүлийн орчинд тоглонгоо хөгжих боломжтойг танилцуулсан.





Хүн болох багаасаа хөтөлбөрийн хүрээнд ахмад багш Ц.Долгормаа бага ангийн багш Б.Оюунханд нар буриад өв соёлоо өвлүүлэн үлдээх зорилгоор монгол ёс заншил, оюун ухаан хөгжүүлэх дугуйлан хичээллүүлж хүүхэд хөгжүүлэх ажилд хувь нэмрээ оруулж байна.



## 5.Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Багш нараас хувь хүний боловсролын талаар сургалт авах хүсэлт ирсэн тул Шинэ монгол сургуулийн эрдмийн хүрээлэнгийн захирал Г.Тогосоос хэрэгцээт 2 багц сургалтыг цахимаар 5 өдөр зохион байгуулсан. Мөн ажлын ачаалал, сэтгэлзүйн стрессээ даван туулах чадварт суралцахын тулд багш, ажилчдын хүсэлтээр цахимаар нийт 12 багш, ажилтанд 10 өдрийн иогийн сургалтад хамруулсан.












## 5.Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

ЕБС-ийн албан хаагчид дундын “ХАМТЫН САН” үүсгэн сар бүр хуримтлуулж хамт олондоо сэтгэлийн дэм үзүүлэх, тусалж дэмжих үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Мөн түүхт 100 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэнтэй холбогдуулан ойн дараа хамт олны алжаал ядаргааг тайлж Хэнтий аймгийн Биндэр сумын байгалийн сайхан болон 2023-2024 оны хичээлийн жилийн уртын амралт эхэлж байгаатай холбогдуулан албан хаагчдынхаа алжаал ядаргааг тайлж байгалийн үзэсгэлэнт газартай танилцахаар “ТЭРЭЛЖ АМРАЛТ”-ын газар тус тус аяласан.









## 5.Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

**Хүүхэд хөгжлийн өрөө**

ЕБС-ийн нийт албан хаагчдын хүүхдийн өрөөг Дорнод аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулсан “БИДНИЙ МАРГААШИЙН ДОРНОД” төслийн уралдаанд 11а ангийн сурагч Х.Цэрэнжаргал “Хүүхэд хамгаалал ба ажлын байран дахь хүүхэд хөгжлийн өрөө” төслөөр амжилттай оролцон Аймгийн Засаг даргаас 5.000.000 төгрөгийн дэмжлэгийг авч хүүхдийн өрөөг тохижуулж хүлээлгэн өгөв. Энэхүү өрөөг тохижуулсанаар нийт албан хаагчдын хүүхдүүд аав ээжийгээ хүлээх орчин нөхцөл бий болсон.

**Малжуулах**

2021-2022 оны хичээлийн жилд галч Ц.Ишсамбуу 50 толгой мал 2022-2023 оны хичээлийн жилд үйлчлэгч Ц.Ганчимэгт 55 толгой мал, 2023-2024 оны хичээлийн жилд Бага ангийн багш Т.Лхамд 46 хонь, 14 ямаа нийт 60 толгой мал, Тогооч Ц.Оюунцэцэгт 40 хонь, 10 ямаа нийт 50 толгой малыг тус тус албан хаагчдад малжуулахаар өгч 3 дахь жилдээ хэрэгжиж байна.







## 6. Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

Сургууль, дотуур байрны орчинд 24 камер үүнээс дотуур байранд 8, сургуулийн гадна, дотор орчинд 16 камер ажиллаж байна. 2023 онд анги бүрийг камержуулах зорилгоор нэмж 13 камер авч суурилуулсан. Нийт сургууль дотуур байрны орчинд 37 камер суурилуулан сургуулийн орчны эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

Мөн Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй аяны хүрээнд сургууль, дотуур байрны 560 суралцагч, 3 челленж, 8 контент, 180 хүүхдэд боршур тарааж, цахим орчинд зөвлөмж мэдээллийг 180 эцэг эх, 560 суралцагч, 52 багш, ажилтанд хүргэн хамтран ажилласан байна.










**6. Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох**




Сургууль, дотуур байрны орчинд 5-12 дугаар ангийн 306 сурагчдаас сургуулийн орчны аюулгүй байдлыг илрүүлэх судалгааг авч нэгтгэн хүүхэд хамгааллын багаар хэлэлцэн, төлөвлөгөө боловсруулан хамтарсан баг, анги удирдсан багш, эцэг эхтэй хамтран ажилласаны үр дүнд зөрчил 40% буурч, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд байхгүй болно.

## 7. Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Боловсрол шинжлэх ухааны газрын зөвлөн туслах зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, төлөвлөгөөний дагуу 3-н ажлыг хийж гүйцэтгэсэн.

2024 оны 02 сарын 27 өдрийн А/04 захирлын тушаалаар Сургууль, дотуур байрны орчны эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг 4 багш, 4 сурагч нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Эрсдэлийн үнэлгээгээр сургууль, дотуур байрны орчинд өөрсдийн нөөцөд тулгуурлан хийж засварлан эрсдэлээ бууруулахад багш, эцэг эхийн оролцоог хангахаас гадна, дотуур байрны сурагчдыг оролцуулан эрсдэлээ бууруулан ажилласаны үр дүнд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэн хүүхдийн хөгжил, оролцоог хангаан эрдэм боловсролтой ирээдүйн зөв иргэдийг төлөвшүүлэх, хүмүүжүүлэхийн төлөө идэвх санаачилга гарган ажилласан хөдөлмөрийг 92%-ийн үнэлгээтэй “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА”-аар шалгарсан.



# 8. Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

“Бага ангийн багшийг дэмжих төсөл” уралдааны оролцогч багш Д.Батчимэг нь 1-5-р ангийн нийт 260 гаруй сурагчдад аливаа эрсдэл учирвал холбогдох шаардлагатай хүмүүсийн утасны дугаараар “**Итгэ, холбогд, тусалъя**” цунхний хаягжилт хийв.

**IV бүсийн сургуулиудын** дунд **“Оролцоод хөгжье” ангийн дарга нарын анхдугаар чуулга** уулзалтыг зохион байгууллаа. Тус чуулганд Баяндун сумын Хүүхдийн зөвлөлийн дарга Х.Хүрэлчулуун, бүсийн сургуулиудын 4 захирал, 4 менежер, 5 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйч, 4 хүүхдийн оролцооны байгууллагын чиглүүлэгч багш, 62 ангийн дарга нарын төлөөлөл, нийт 80 хүн оролцлоо. Чуулганы үр дүнд ангийн дарга нар болоод сурагчдын өмнө тулгамдаж байгаа шийдвэрлэж чадахгүй олон асуудлыг хэлэлцэн орон нутгийн удирдлага, сургуулийн удирдлагуудад танилцуулан, дуу хоолойгоо хүргэж цаашдын хийх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон үйл ажиллагаа болсон.






# 8. Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

## Ангиараа 50 ном уншицгаая

Сурагчдын өвлийн амралтыг үр дүнтэй өнгөрүүлэх, бүтээлчээр ном унших дадал хэвшилтэй болгох зорилгоор “**НОМ ДОТОР ЗАМ БИЙ**” уриатай "**АНГИАРАА 50 НОМ УНШИЦГААЯ**" уралдааныг 3 дахь жилдээ амжилттай зохион явууллаа.

Энэ жилийн уралдааны дүнгээ гаргахдаа "ШИЛДЭГ УНШИГЧ АНГИ"-2, "ШИЛДЭГ УНШИГЧ СУРАГЧ"-5, "ИДЭВХТЭЙ УНШИГЧ СУРАГЧ"-4 шалгаруулж олон сурагчийг урамшуулж, ном унших үйл ажиллагааг дэмжин ажилласан. Мөн “Хамтдаа уншицгаая” үйл ажиллагаагаа дүгнэж сар бүр уншлагын ахиц үр дүнг тооцох, уншлагыг идэвхижүүлэх зорилгоор сард 1 удаа “НОМ ЗАМ” хэлэлцүүлгийг хийснээр анги бүр бусад ангиуддаа өөрсдийн уншсан номоо танилцуулж, бусдад илтгэх чадвараа танилцуулах боломжийг бүрдүүлсэн.











# 8. Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

## Завсарлагааны гимнастик

Б.Мөнхсайхан багштай 2016 оны төгсөлтийн хамт олноос санаачлан зохион байгуулж, жил бүр уламжлал болгон зохион явуулдаг. "**ЗАВСАРЛАГААНЫ ХӨГЖИМТ ДАСГАЛ**"-ыг 2023-2024 оны хичээлийн жилд Д.Батчулуун багштай 12а ангийн хамт олон хичээлийн жилийн турш дунд, ахлах ангиудын дунд амжилттай зохион байгуулж, үүний үр дүнд хөдөлгөөний эвсэлтэй болохоос гадна сурагчдыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлсэн.





# АНХААРАЛ ТАВЬСАН
# ТА БҮХЭНДЭЭ БАЯРЛАЛАА